

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ****Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасны дагуу Улсын Их Хурал нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхтэй бөгөөд парламентын нээлттэй сонголт бол Улсын Их Хурал хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдолтой, олон нийтийн оролцоотой механизм болдог.

Энэхүү зорилго, ач холбогдлыг тусгаж Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах Засгийн газрын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн биелэлтийг Улсын Их Хурлаас хянан шалгахтай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж 2024 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Мөн уг хууль батлагдсантай холбоотойгоор Нийтийн сонголын тухай хуульд заасан ерөнхий хяналтын сонголыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу явуулахаар хуульчилсан.

Дээр дурдсанаар парламентын сонголт зохион байгуулах нь өндөр ач холбогдолтой хэдий ч сонголын үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлт, үр дүнг тооцож, шалгах үр дүнгийн сонголын зохион байгуулах нь парламентын аливаа шийдвэр, шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний биелэлтийг тооцох, нээлттэй сонсох ач холбогдолтой юм.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болох зорилгын хүрээнд 2021-

2030 онд Улсын Их Хурлын хууль тогтоох, бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чадавх сайжирч парламентын засаглал бэхэжсэн байхаар хүрэх үр дүнг тодорхойлсон.

Иймд Монгол Улсын Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой эрх зүйн үндсийг хуульчлах шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ.

Хуулийн төсөл нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой харилцаанд хамаарах бөгөөд үр дүнгийн сонсгол зохион байгуулах эрх зүйн үндсийг тодорхойлно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар сонсголын үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлт, үр дүнг тооцох хууль эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзэж байна.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг сайжруулах зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ